



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 8/01

Чингис хот

Т.Жанчивыг шилжүүлэн томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4, Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг, Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоол, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 34/31 дугаартай тушаалаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын 2.1 дэх хэсэг, “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”, Барилга хот байгуулалтын сайдын 2017 оны 200 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоолоор Мэргэжлийн хяналтын байгууллагын чиг үүрэг бусад яам, агентлаг руу шилжиж байгаатай холбогдуулан аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүч, харилцаа холбооны хяналтын улсын байцаагч Тэрбишийн Жанчивыг 2023 оны 1 дүгээр сарын 02-оос эхлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст Эрчим хүч, харилцаа холбооны хяналтын улсын байцаагчаар шилжүүлэн томилсугай.

2. Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Э.Мөнх-Эрдэнэ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Ш.Эрдэнэжаргал	Хүний нөөц, дотоод ажил, агентлаг хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Б.Дарханбаатар	Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
	Э.Ариунтунгалаг	Нягтлан бодогч

2.

Т.Баяртуяа

Нярав

3.Т.Жанчивын цалинг ТЗ-6-5 шатлалаар тогтоон, үндсэн цалинг 853,375 (найман зуун тавин гурван мянга гурван зуун далан тав) төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 25 хувиар, зэрэг дэвийн нэмэгдлийг 24 хувиар, мэргэшлийн зэргийн нэмэгдлийг 10 хувиар тус тус тооцож олгохыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

4.Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг, зорилтыг хэрэгжүүлэн, холбогдох хууль тогтоомжийг чанд мөрдөж ажиллахыг Т.Жанчивт үүрэг болгосугай.

5.Т.Жанчивын ажлыг зохих хууль, журмын дагуу хүлээлцүүлж, холбогдох эд хөрөнгийг бүртгэлжүүлэн авахыг Комиссын бүрэлдэхүүн (Э.Мөнх-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР